



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН ТАЙЛАН

МҮОХ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ЗОРИЛГОДОО БҮРЭН НИЙЦЭЭГҮЙ, ДҮРМИЙГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ШААРДЛАГА ҮҮССЭН БАЙНА

**АУДИТЫН СЭДЭВ: “МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛИМПИЙН ХОРООНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮН”**

АУДИТЫН КОД: УАГ-2020/01

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261885, цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Д.Энхдалай

Утас: 261885, цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Эрдэнэзул

Утас: 261740, цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn

Аудитор А.Даваадорж

Утас: 261628, цахим хаяг: davaadorja@audit.gov.mn

Аудитор Д.Болор-Эрдэнэ

Утас: 261628, цахим хаяг: bolor-erdened@audit.gov.mn

Аудитор Б.Батчимэг

Утас: 261456, цахим хаяг: batchimegb@audit.gov.mn

Аудитор Э.Бүгүнүтэй

Утас: 261805, цахим хаяг: bugunuteie@audit.gov.mn

Аудитор Ч.Бумдарь

Утас: 261729, цахим хаяг: bumdarich@audit.gov.mn

Улаанбаатар хот
2021 оны 2 дугаар сар



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.1.10, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын үндэсний олимпийн хорооны үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монголын үндэсний олимпийн хороо, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тус тус хүргүүлэхийг Аудитын хоёрдугаар газар /Ц.Наранчимэг/-т даалгасугай.

3. Аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монголын үндэсний олимпийн хорооны ерөнхийлөгчид зөвлөсүгэй.

4. Аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хоёрдугаар газар /Ц.Наранчимэг/-т даалгасугай.

5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын багт үүрэг болгосугай.



Д.ЗАНДАНБАТ

\\10.10.10.20\Bichig_KhinlegYavkhan_Bichig\2021\0210auditin 2-R Gazar7.Docx

001310352

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн жагсаалт	4
Зураг, дүрслэлийн жагсаалт	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5
Ерөнхий мэдээлэл.....	6
БҮЛЭГ 1. МҮОХ-ны үйл ажиллагааны үндсэн зарчмууд нь Олимпийн Хартид нийцэж байгаа боловч хэрэгжилт хангалтгүй, зарим эрх зүйн акт нь хууль, дүрэм, журамтай нийцээгүй байна.	7
МҮОХ нь үйл ажиллагааны үндсэн зарчмаа хангалттай хэмжээнд баримтлан ажиллаагүй байна.....	7
Хянан шалгах зөвлөл нь чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, үйл ажиллагаа нь хангалтгүй байна.....	10
Үйл ажиллагааны зорилго, зорилтуудаа зарим талаар үр дүнтэй, оновчтой хэрэгжүүлээгүй байна.....	11
БҮЛЭГ 2. МҮОХ-ны хөрөнгө оруулалт, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт, мэдээллийн ил тод байдал хангалтгүй байна.....	14
Орлогын эх үүсвэрийг бодитой төлөвлөөгүй, хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.	14
МҮОХ-ны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт, сахилга, хариуцлага дутагдаж байна.....	16
Хөрөнгө ашиглах, зарцуулахад гаргасан зарим шийдвэр нь МҮОХ-ны эрх ашигт нийцэхгүй байна.....	17
МҮОХ санхүүгийн үйл ажиллагаандаа НББ-ийн бодлогын баримт бичиг боловсруулан батлуулж мөрдөөгүй байна.	19
Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн ашиглалт, зарцуулалт үр дүнг тооцох шалгуур үзүүлэлт хангалтгүй байна.	21
Дүгнэлт.....	25
Зөвлөмж.....	26
Шалгагдагч байгууллагын ирүүлсэн санал, хүсэлт.....	27
Хавсралтууд	30

Товчилсон үгийн тайлбар

АОЗ	Азийн олимпийн зөвлөл
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БТСТХ	Биеийн тамир, спортын тухай хууль
ТББТХ	Төрийн бус байгууллагын тухай хууль
МҮОХ	Монголын Үндэсний олимпийн хороо
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НГЗБА	Нийслэлийн газар зохион байгуулалтын алба
ХДЖ	Хөдөлмөрийн дотоод журмын
ҮОХ	Үндэсний олимпийн хороо
ОУОХ	Олон улсын олимпийн хороо
ОУЭСН	Олон Улсын эв санааны нэгдэл
ХШЗ	Хянан шалгах зөвлөл

Хүснэгтийн жагсаалт

№	Хүснэгт	Нэр	Хуудас
1	Хүснэгт №1	Спорт холбоодын сонгуульт албан тушаал хавсран гүйцэтгэгч	7
2	Хүснэгт №2	Орлогын эх үүсвэр	13
3	Хүснэгт №3	Газрын эзэмшилд орсон өөрчлөлт	16-17
4	Хүснэгт №4	Газрын эзэмшилд орсон өөрчлөлтийн зөрүү	17
5	Хүснэгт №5	Арилжааны банкнаас авсан зээл, хүүгийн төлбөр	18
6	Хүснэгт №6	Санхүүгийн үзүүлэлтүүд 2012-2019	18-19
7	Хүснэгт №7	Санхүүгийн тайлан дахь зөрүүтэй илэрхийлэл	19

Зураг, дүрслэлийн жагсаалт

№	Дүрслэл	Нэр	Хуудас
1	Дүрслэл №1	Дүрэм шинэчлэн баталсан гишүүдийн хурлын бүрэлдэхүүн	6
2	Дүрслэл №2	Гадаад эх үүсвэр 2012-2019 он	14
3	Дүрслэл №3	2018-2019 оны зардлын гүйцэтгэл /төрлөөр/	25
4	Дүрслэл №4	2018-2019 оны зардлын гүйцэтгэл /хувиар/	25
5	Дүрслэл №5	Хөтөлбөрт хамруулах үе шат	21
6	Дүрслэл №6	Хөтөлбөрийн санхүүжилт 2012-2019	22
7	Дүрслэл №7	Олимпийн наадмын амжилт олон улсад эзлэх зэрэглэл	23
8	Дүрслэл №8	Олимпийн түнш хөтөлбөрийн орлого	24

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 04 дүгээр тогтоол, Аудитын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/53 дугаар тушаалаар батлагдсан сэдвийн дагуу, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлд заасны дагуу “Монголын үндэсний олимпийн хорооны үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт

Монголын Үндэсний олимпийн хорооны 2012-2019 оны байдлаарх үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үр дүнд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн болон шалгадагч этгээдэд хүргүүлж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Зорилтыг хангахын тулд дараах дэд асуудлуудын хүрээнд аудит хийлээ. Үүнд:

- МҮОХ-ны үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх;
- МҮОХ-ны хөрөнгө оруулалт, санхүүгийн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитад Монголын Үндэсний олимпийн хорооны 2012-2019 оны байдлаарх үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үр дүнд дүн шинжилгээ хийж, салбар спортын холбоод, шаардлагатай харилцагч байгууллагуудын үйл ажиллагааг хамруулсан.

Аудитын явцад МҮОХ-ны дүрэм, хөрөнгийн бүртгэлтэй холбоотой тусгайлсан асуудлаар хамрах хүрээг 2012 оноос өмнөх үйл ажиллагаанд нэмэлт горим, сорил хэрэгжүүлэхээр аудитын төлөвлөгөөнд МҮЕА-ын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар өөрчлөлт оруулсан болно.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Монгол Улсын Төрийн аудитын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглаж шалгадагч этгээдийн холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийн, асуулга, лавлагаа, судалгаа авч, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалыг шалгаж, дүн шинжилгээ хийх горим хэрэгжүүлж, асуудлын шинжилгээ арга зүй, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулан аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон авч үзлээ. Үүнд:

- Олимпийн Харти;
- Монголын Үндэсний олимпийн хорооны дүрэм;
- Биеийн тамир, спортын тухай хууль;
- Төрийн бус байгууллагын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Иргэний хууль;
- Бусад хууль, дүрэм, журам.

Ерөнхий мэдээлэл

Монголын Үндэсний Олимпийн хороо нь 1956 онд байгуулагдан, 1962 онд ОУОХ-нд гишүүн байгууллагаар элссэн үндэсний болон олон улсын хэмжээнд олимпийн хөдөлгөөнийг хөгжүүлэх зорилго бүхий Төрийн бус байгууллага юм.

МҮОХ нь олимпийн наадам, Олон улсын олимпийн хорооны ивээл дор зохиогдох тив, бүс болон дэлхийн спортын олон төрөлт тэмцээнд Монгол Улсыг төлөөлөх онцгой эрхийг Олимпийн Хартийн дагуу дангаар эдэлдэг.

Мөн Олимпийн Харти, Олон Улсын Олимпийн хороо, Дэлхийн допингийн эсрэг дүрмийн шийдвэр, Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, бусад хууль тогтоомжийг хүндэтгэн сахиж, төр, засгийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран ажиллахаар дүрэмдээ заажээ.

Монгол Улс 1964 оноос эхлэн 15 удаагийн олимпийн наадамд тамирчдаа илгээж, 26 медаль авсан байна.

Олимпын наадамд Монгол Улс				
Медаль	Алт	Мөнгө	Хүрэл	Нийт
	2	10	14	26
Зуны олимпод оролцсон он				
1964 • 1968 • 1972 • 1976 • 1980 • 1984 • 1988 • 1992 • 1996 • 2000 • 2004 • 2008 • 2012 • 2016				
Өвлийн олимпод оролцсон он				
1964 • 1968 • 1972 • 1976 • 1980 • 1984 • 1988 • 1992 • 1994 • 1998 • 2002 • 2006 • 2010 • 2014 • 2018				

МҮОХ-ны Чуулган, Гишүүдийн хурал, Гүйцэтгэх зөвлөл, Ерөнхийлөгч гэсэн удирдлагын тогтолцоотой байхаар дүрэмдээ заасан бөгөөд Гишүүдийн хурлын 2017 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор МҮОХ-ны ажлын албыг 21 орон тоотой ажиллуулахаар баталсан байна.

МҮОХ-ны дүрэмд олимпийн үзэл санаа, спортыг хөгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулах санхүүгийн эх үүсвэрийг ОУОХ, АОЗ болон гадаад, дотоод байгууллага, хувь хүмүүсээс олгосон санхүүжилт, гишүүнчлэлийн татвар, хандив тусламж, бусад орлогоос бүрдүүлэхээр заажээ.

БҮЛЭГ 1. МҮОХ-ны үйл ажиллагааны үндсэн зарчмууд нь Олимпийн Хартид нийцэж байгаа боловч хэрэгжилт хангалтгүй, зарим эрх зүйн акт нь хууль, дүрэм, журамтай нийцээгүй байна.

МҮОХ нь үйл ажиллагааны үндсэн зарчмаа хангалттай хэмжээнд баримтлан ажиллаагүй байна.

1.1 МҮОХ нь Монгол Улсын нутаг дэвсгэрт олимпийн хөдөлгөөнийг хөгжүүлэх зорилго бүхий, Олимпийн наадам бүс, тив, дэлхийн тэмцээнүүдэд улсаа төлөөлдөг онцгой эрхтэй, биеийн тамир спортын салбарын бүлэг, давхаргын эрх ашгийг хамгаалах, нийгмийн тусын тулд үйл ажиллагаа явуулдаг, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага юм.

1.2 Иргэний хуулийн 36 дугаар зүйлийн 36.1¹-д “Нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий хуулийн этгээдийг ...” хэлнэ гэж зохицуулсан байна.


1.3 МҮОХ-ны улсын бүртгэлийн гэрчилгээнд байгууллагын гишүүдийн тоо-1, 100 хувийн хувьцаа эзэмшигч нь Дэмчигжав овогтой Загдсүрэн гэсэн байх бөгөөд Төрийн бус байгууллагын тухай хуулийн 6 дугаар зүйлд “Үүсгэн байгуулагчдаас төрийн бус байгууллага байгуулах тухай шийдвэр гаргаж байгууллагын дүрмийг баталснаар төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулсанд тооцох бөгөөд улсын бүртгэлд бүртгүүлснээр хуулийн этгээдийн эрх эдэлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

1.4 МҮОХ-ны хувьд чуулган, гишүүдийн хурал нь ТББТХ-ийн 11 дүгээр зүйлийн 2² дахь хэсэгт зааснаар төрийн бус байгууллагын эрх барих байгууллага бөгөөд хуульд заасан эрхийг эдлэхээр байна.

1.5 МҮОХ 2016 оны бүх гишүүдийн хурлаар нийт 101 гишүүнээс 68 гишүүн оролцож, хурлын бүрэлдэхүүний олонхийг олимпийн бус төрлийн Холбоод бүрдүүлж 2010 оны дүрмийг шинэчлэн баталсан нь Олимпийн Хартийн 28.3³, дүрмийн 6.2⁴-г тус тус зөрчсөн байна. Уг асуудал шүүхэд маргаантай байна.

Дүрэм шинэчлэн баталсан гишүүдийн хурлын бүрэлдэхүүн

Дүрслэл №1



Эх сурвалж 2016 оны гишүүдийн хурлын материал

¹ Хуулийн 36.1-д Нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий хуулийн этгээдийг холбоо гэнэ.

² Хуулийн 11 дүгээр зүйлийн 2-т Гишүүнчлэлтэй төрийн бус байгууллагын дүрэмд өөрөөр заагаагүй бол түүний эрх барих байгууллага нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрх бүхий удирдах зөвлөл байна.

³ Хартийн 28.3-т МҮОХ-ны гишүүд болон Гүйцэтгэх удирдлагын санал хураалтанд оролцогчдын олонхийг дүрмийн 1.2-т заасан Үндэсний спортын холбоод болон тэдний төлөөлөл бүрдүүлнэ.

⁴ Дүрмийн 6.2 Гишүүдийн санал хураах бүрэлдэхүүн. Олимпийн наадмын хөтөлбөрт ордог спортын олон улсын холбооны гишүүн үндэсний холбоод нь МҮОХ-ны /тухайлбал Олимпийн чуулган ба Гишүүдийн хурал/ нийт санал хураалтын бүрэлдэхүүний олонхийг бүрдүүлэх ёстой.

1.6 Гишүүдийн хурлын 2010 онд баталсан дүрмийн 6.2⁵, 2016 оны 5 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан дүрмийн 5.1.1⁶-д чуулган, гишүүдийн хурлын бүрэлдэхүүний олонхыг олимпийн наадмын хөтөлбөрт багтдаг Олон улсын спорт холбоодын гишүүн үндэсний холбоод байхаар заасан ч хэрэгжилт хангалтгүй, Хартийн зарчим алдагдсан байна.

1.7 МҮОХ-ны удирдлагууд болон үндсэн орон тооны албан хаагч нь Спорт холбоодын сонгуульт албан тушаал хавсран эрхэлж байна Үүнд:

Спорт холбоодын сонгуульт албан тушаал хавсран гүйцэтгэгч

Хүснэгт №1

МҮОХ-ны үндсэн орон тооны албан тушаалтан	Спорт холбооны сонгуульт ажил	Хугацаа
МҮОХ-ны ерөнхийлөгч Д.Загдсүрэн	Хүндийн өргөлтийн холбооны ерөнхийлөгч	2012-2019
Тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Баттүшиг	Монголын Бадминтоны холбооны ерөнхийлөгч	2017-2019
Тэргүүн дэд ерөнхийлөгч Э.Мөнх-Очир	Монголын Самбо бөхийн холбооны ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч; Монголын Буудлага спортын холбооны ерөнхийлөгч; Монголын Биатлоны холбооны ерөнхийлөгч;	2012-2014 2014-2017 2008-2017 2016-2017
Ерөнхий нарийн бичгийн дарга, Дэд ерөнхийлөгч Ц.Дамдин	Монголын Олимпод оролцогчдын холбооны ерөнхийлөгч	2012-2017 2017-2019
Ерөнхий нарийн бичгийн дарга, Зөвлөх Ж.Отгонцагаан	Спортын сэтгүүлчдийн холбоо	2012-2019
Спорт холбоод хариуцсан мэргэжилтэн З.Галхүү	Монголын Бадминтоны холбооны ерөнхий менежер	2017-2019

1.8 ТББТХ-ийн 13 дугаар зүйлийн 3⁷-д санал хураалт, шийдвэр гаргах үйл ажиллагаанд эрх бүхий албан тушаалтан оролцохгүй, мөн Дүрмийн 3.8-д МҮОХ нь ОУОХ-ны ёс зүйн дүрмийг сахин ажиллах тухай зохицуулсан байна.

1.9 ОУОХ-ны ёс зүйн дүрмийн *Шударга ажиллах бүлэг 2 дугаар зүйл*⁸-д заасныг сахилгүй шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцож байгаа нь бусдад давуу байдал олгох, олон нийтийн итгэлийг эвдэх, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн байна.

1.10 Гишүүн байгууллагын эрх бүхий этгээд нь сонгуульт ажил, үүргээс огцорсон, эсхүл татгалзах тохиолдолд төлөөлөх эрхийн тухай МҮОХ-ны дүрэмд тодорхой тусгаагүйгээс түүний оронд тус байгууллагыг төлөөлөх этгээдийн эрх нь хязгаарлагдаж байна.

1.11 Түүнчлэн Дүрмийн 14.3⁹-т гишүүний эрх дараагийн чуулган хүртэл хадгалагдахаар заасан нь холбооны гүйцэтгэх удирдлагын статусаа алдсан

⁵ 2010 оны Дүрмийн 6.2. Гишүүдийн санал хураах бүрэлдэхүүн. Олимпийн наадмын хөтөлбөрт ордог спортын олон улсын холбооны гишүүн үндэсний холбоод нь МҮОХ-ны /тухайлбал Олимпийн чуулган ба Гишүүдийн хурал/ нийт санал хураалтын бүрэлдэхүүний олонхийг бүрдүүлэх ёстой.

⁶ 2016 оны Дүрмийн 5.1 МҮОХ нь дараах гишүүнчлэлтэй байна: 5.1.1 Олимпийн наадмын хөтөлбөрт багтдаг Олон улсын спорт холбоодын гишүүн үндэсний бүх холбоод. Эдгээр холбоод нь ямар ч тохиолдолд МҮОХ-ны гишүүн байх бөгөөд Олимпийн Хартийн дагуу МҮОХ-ны Чуулган, Гишүүдийн хурал, Гүйцэтгэх зөвлөлд олонхийг бүрдүүлнэ.

⁷ Хуулийн 13 дугаар зүйлийн 3-д Удирдах зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэх асуудлаар гишүүн сонирхлын зөрчилтэй байвал тухайн гишүүн энэ тухайгаа тайлбарлаж санал хураалтанд оролцохгүй. Удирдах зөвлөлийн хуралдаан даргалагч сонирхлын зөрчилтэй байвал хуралдааныг өөр гишүүн даргална.

⁸ Ёс зүйн дүрмийн 2 Олимпийн хөдөлгөөний удирдлагууд үйл ажиллагаандаа маш сонор сэрэмжтэй, нямбай хандах ёстой. Тэд цаг ямагт шударга байдлыг дээдэлж, ялангуяа шийдвэр гаргах үедээ үл ялгаварлах, асуудалд бодитой хандах, бусдын нөлөөнд автахгүй ба мэргэжлийн өндөр ур чадварыг үзүүлэх ёстой. Тэд Олимпийн Хөдөлгөөний нэр хүндийг унагах эрсдэлтэй үйлдэл хийх ёсгүй.

⁹ Дүрмийн 14.3-т Мандатын комиссын илтгэл: Мандатын комиссын илтгэлийг хэлэлцэн баталснаар МҮОХ-ны Чуулганы төлөөлөгчид МҮОХ-ны гишүүнээр тооцогдож, бүрэн эрх нь нээгдэнэ. Гишүүний эрх дараагийн чуулган хүртэл хадгалагдана.

төлөөлөгч буюу гишүүн байгууллагатай хамааралгүй этгээд гишүүдийн хурал болон чуулганд оролцох нөхцөлийг бүрдүүлж байна.

1.12 ОУОХ-ноос 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр ирүүлсэн ҮОХ-ны гишүүнчлэлийн тухай зөвлөмж бичигт: *“Үндэсний холбоодоос томилогдсон төлөөлөгчид нь ҮОХ-ны бие даасан гишүүн биш бөгөөд холбооны гүйцэтгэх удирдлагын статусаа алдахад холбоог төлөөлөх гишүүний эрхээ мөн адил алдана. Өөрөөр хэлбэл тухайн гишүүн холбооны гүйцэтгэх удирдлагын статусаа алдах хүртэл эсвэл холбоо гүйцэтгэх удирдлага дахь одоогийн гишүүдээс төлөөлөгчийг сонгох шийдвэр гаргах хүртэл ҮОХ-ны Их хуралд холбоог төлөөлөхөөр сонгогдсон гэж үзнэ. Мөн дүрмийн 14.3 дугаар зүйлийн эхний догол мөрийг өөрчлөх, зөрүүтэй ойлголт төрүүлэхээр бол хасах эсхүл дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахаар бол бид татгалзах зүйлгүй”* гэсэн тайлбар ирүүлсэн байна.

1.13 МҮОХ-ны гишүүдийн 2016 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн хурлаар дүрмийн нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэн баталгаажуулж, үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн нь Олимпийн Хартид заасан ҮОХ-г хүлээн зөвшөөрөх журмын 1.3¹⁰-ийг зөрчиж байна.

1.14 Уг дүрмийг ОУОХ-ноос хянан засварлаж 2017 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Хартид нийцүүлэн баталгаажуулж ирүүлснийг гишүүдийн хурлаар хэлэлцүүлэлгүй, 2016 оны гишүүдийн хурлаар баталсан мэтээр үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

1.15 Байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм журмыг боловсруулсан ч хангалттай хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

- ХДЖ-ын 7.2, 7.3-т МҮОХ-ны ажилтан нь ажлаа улирал, жилээр төлөвлөх, ажил олгогч нь ажлын гүйцэтгэлийг хагас жил, жилээр үнэлж дүгнэх ажил хэрэгждэггүй;
- ХДЖ-ын 2.2-т заасан байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журмыг боловсруулж, батлан үйл ажиллагаандаа мөрдөөгүй;
- Гадаад харилцааны журмын 2.4-т заасан “Олон улсаас ирсэн и-мэйлд танилцуулах хуудас хийж, удирдлагууд болон холбогдох хүмүүст танилцуулан хариуг илгээх” ажил журмын дагуу хийгдэж ирээгүй байна. ОУ-аас ирсэн и-мэйлийн холбогдох баримт материал зөвхөн гадаад харилцаа хариуцсан албан хаагчийн и-мэйлд хадгалагдаж, байгууллагын бичиг хэрэг, архивд бүртгэгдэгүй;
- Тэтгэмж, тусламж олгох болон зарим арга хэмжээнд зардал гаргах журмын 7.1.5-д Хянан шалгах зөвлөлийн гишүүдэд санхүүгийн баримт болон дотоод ажил шалгах ажлыг гүйцэтгэсний урамшуулал олгохоор заасан нь Олимпийн Хартийн 28.1.6 болон Дүрмийн 6.6 - тай зөрчилдөж байна.

1.16 Олимпийн Хартийн 4 дүгээр бүлгийн 5¹¹-д ҮОХ, бусад байгууллагатай хамтран ажиллах тухай заасан ч хамтын ажиллагаа нь шагнал урамшууллын хүрээнээс хэтрэхгүй, биеийн тамир, спортыг хөгжүүлэх асуудлаар санал боловсруулж, төр, засгийн байгууллагад өргөн барих, шийдвэрлэхэд хамтын ажиллагаа хангалтгүй байна.

¹⁰ ҮОХ-ны батлуулсан дүрэмд өөрчлөлт, нэмэлт хийх бол энэ талаар ОУОХ-нд мэдэгдэн түүнийг зөвшөөрүүлнэ.

¹¹ Хартийн 4-р бүлгийн 5-д ҮОХ-д нь эрхэм зорилгоо биелүүлэх үүднээс засгийн газрын байгууллагуудтай харилцан, хамтран ажиллаж болно. Гэхдээ Олимпийн Харттай зөрчилдөх аливаа үйл ажиллагаанд оролцож, хамтарч болохгүй. ҮОХ-д нь мөн төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж болно.

1.17 МҮОХ нь дүрмийн 4.15¹² болон Олимпийн Хартийн 14 бүлэг 4.10.2¹³, 28.2.4¹⁴, 50 бүлэг 3¹⁵-д заасны дагуу Олимпийн өмчийг зөвшөөрөлгүй ашиглахын эсрэг тууштай тэмцэх, өөрийн улсын нутаг дэвсгэрт олимпийн өмчийг хамгаалах үүргээ хангалттай хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

- МҮОХ болон Скайтел ХХК-ийн хооронд хийгдсэн 2016 оны Түншлэлийн гэрээ нь Скайтел ХХК болон түүний охин компани Скаймедиа компанид Олимпийн таван цагариг болон RIO 2016 Олимпийн эмблемийг ашиглах эрхийг олгож Олимпийн Хартийг зөрчсөн;
- Олимпийн наадамд бэлтгэх Үндэсний хорооны 2019 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн шийдвэрээр үүсгэн байгуулагдсан Токио олимп сангийн үйл ажиллагаанд Токио 2020 олимпийн нэр, эмблем болон таван цагаригийг ашигласан.

Хянан шалгах зөвлөл нь чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, үйл ажиллагаа нь хангалтгүй байна.

1.18 МҮОХ-ны дүрмийн 3 дугаар бүлэгт удирдлага зохион, байгуулалт бүрэлдэхүүнийг тогтоож, түүний эрх үүргийг тодорхойлсон бөгөөд Чуулган, Гишүүдийн хурал, Гүйцэтгэх зөвлөл, Ерөнхийлөгч гэсэн удирдлагын тогтолцоотой байна.

1.19 МҮОХ-ны гишүүдийг мэдээллээр хангах зохицуулалт бага, гишүүдийн хурлаар хэлэлцэх асуудал, холбогдох мэдээллүүд, хурлын тэмдэглэлийг тухай бүр хүргүүлж хэвшээгүй нь гишүүдийн зүгээс шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, хяналт тавих нөхцөл бүрдээгүй байна.

1.20 Ерөнхийлөгчийн 2018 оны 62 дугаар “Ажлын байрны тодорхойлолтыг батлах тухай” тушаалд зөвлөх болон тэргүүн дэд ерөнхийлөгчийн ажлын байрны тодорхойлолтыг тусган батлаагүй байна.

1.21 МҮОХ-ны дүрэмд Хянан шалгах зөвлөлтэй байхаар заасан бөгөөд дүрмийн биелэлт, ерөнхийлөгчийн болон гүйцэтгэх зөвлөлийн шийдвэр Олимпийн Харт, хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, санхүүгийн болон спорт холбоодын үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөмж өгөх чиг үүрэгтэй ч архив, бичиг хэрэг, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийж, бусад чиг үүргийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

1.22 Хянан шалгах зөвлөл нь сүүлийн 8 жилд дотоод ажил хэргийн 7, хамтын ажиллагааны 4, санхүүгийн 2, үйл ажиллагааны тайлангийн чанарыг сайжруулахаар 1 нийт 14 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилтийг үнэлж, дүгнээгүй байна.

¹² Дүрмийн 4.15. Олимпийн тэмдэг, туг, уриа, сүлд, дуулал, таних тэмдэг, бэлгэдэл, галт бамбар гэх мэт олимпийн өмч болон “Олимпийн наадам”, “Олимпиад” гэсэн нэр ба энэ 2 нэрээр хязгаарлагдахгүй ашиглах онцгой эрхийг ОУОХ эзэмшинэ. МҮОХ нь МҮОХ-ны дүрмийг зөрчих болон олимпийн өмчийг зөвшөөрөлгүй ашиглахын эсрэг тууштай тэмцэх ба ОУОХ-ны их үйл хэргийн төлөө олимпийн өмчийг хамгаалахад онцгой анхаарна.

¹³ Олимпийн хартийн бүлэг 14-ийн 4.10.2. Дээрхийн нэгэн адил тухайн ОНЗБХ -ны Олимпизмтэй хамаарал бүхий эмблем, билэг тэмдэг, тэмдэг, тэмдэглэгээ зэргийг тухайн ОУОХ-ноос урьдчилан бичгээр авсан зөвшөөрөлгүй бол зар сурталчилгаа, арилжаа, ашиг олох зэрэг зорилгоор хэрэглэж болохгүй.

¹⁴ Олимптйн хаотийн 28.2.4. ОУОХ-д нь өөрийн улсын нутаг дэвсгэрт Олимпийн эд хөрөнгө, өмчийг хамгаалахад ОУОХ-нд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана.

¹⁵ Олимпийн хартийн бүлэг 50-ын 3. Олимпийн наадамд зориулан бүтээсэн бүх бэлгэ тэмдгийг олимпийн эмблем гэж үзнэ. Уг эмблемийн хийцийг ЗБХ-ноос ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөр батлуулахаар өргөн мэдүүлнэ. Уг бэлгэ тэмдгийг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс урьдчилан бичгээр зөвшөөрөл аваагүй ОУОХ-д болон улсуудад арилжааны зорилгоор хэрэглэгдэхгүй.

Үйл ажиллагааны зорилго, зорилтуудаа зарим талаар үр дүнтэй, оновчтой хэрэгжүүлээгүй байна.

1.23 МҮОХ нь Олимпийн Харти болон Монгол Улсын Үндсэн Хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль бусад хууль тогтоомжийг баримтлан, өөрийн дүрмийн хүрээнд төр, засгийн болон Төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран ажиллах бөгөөд Монгол Улс дахь олимпийн хөдөлгөөнийг хөгжүүлэх зорилго бүхий байгууллага юм.

1.24 МҮОХ нь дүрэмдээ заасан зорилго, зорилтуудын хэрэгжилт, үр дүнг үнэлж, тайлагнаж хэвшээгүй байна.

1.25 Монгол Улсад олимпийн хөдөлгөөнийг түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх, хамгаалах, сурталчлах зэрэг ажил зохион байгуулдаг ч үр дүнтэй, оновчтой арга хэмжээ болж байгаа нь эргэлзээтэй байна. Тухайлбал,

- "Таван цагариг бат холбоо" урианы дор олимпийн хөдөлгөөнийг сурталчлан бамбарт аяныг орон нутагт өрнүүлсэн,
- МҮОХ-ны "Алтан түнш" Рио Тинто компанитай хамтран Оюу толгой төслийн талбайд бамбарыг залах арга хэмжээ,
- Хилийн цэргийн ангиудад олимпийн танхим шинээр байгуулах, хилчдийн олимпийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор "Дархан хил-Олимп" бамбарын аяныг зохион байгуулдаг байна.

1.26 МҮОХ нь тамирчид, дасгалжуулагчдыг хөгжүүлэх, амжилтыг ахиулах, бүх нийтийн спортыг дэмжин хөгжүүлэх талаар ОУОХ-ны эв санааны нэгдлийн сангаас хэрэгжүүлдэг хөтөлбөр арга хэмжээнд хамруулах бэлтгэл ажлыг хангаж ажилладаг байна.

1.27 Хөтөлбөрийн хүрээнд тамирчдын бие бялдар, сэтгэл зүй, техник технологи, эрүүл мэнд, сэргээш, хориотой эм бэлдмэлийн тухай сургалтуудыг тогтмол авдаг ч сургалтын үр дүн, үр нөлөөний тухай мэдээлэл солилцох, түгээн дэлгэрүүлэх, тайлбарлан таниулах ажил хангалттай хэрэгждэггүй байна.

1.28 Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Жендерийн үндэсний хорооноос гаргасан хөтөлбөр, НҮБ болон ОУОХ, ЕХ-ноос баталсан гэрээ конвенцийн дагуу системтэй үйл ажиллагааг зохион байгуулж, мэдээллийг түгээх спортод ялгаварлан гадуурхах, хүчирхийлэх хэлбэрийг эсэргүүцэж, биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд аливаа сөрөг нөлөөллийн эсрэг тэмцэх үйл ажиллагаа хангалтгүй, төлөвлөлтийн шатанд байна.

1.29 Энэ талаар "Эмэгтэй удирдагч сан"-аас гаргасан судалгаа, дүгнэлт зөвлөмжийн дагуу мэргэжлийн спортын холбоодыг жендэрийн талаарх ойлголт, мэдлэгтэй болоход тусгайлан удирдамж боловсруулж, мэргэжлийн шинжээчдийн баг, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, спортын шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулахад зайлшгүй анхаарч ажиллах шаардлагатай байна.

Допингийн эсрэг үйл ажиллагааны талаар:

1.30 Дэлхийн Допингийн эсрэг агентлагийн дүрмийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх, үүнтэй холбогдуулан допингийн эсрэг МҮОХ-ны бодлого ба дүрэм, гишүүнчлэл, санхүүжилтийн шаардлага болон үр дүнгийн журмыг Дэлхийн допингийн эсрэг агентлагийн дүрэмд нийцүүлж боловсруулах ажил хийгдээгүй байна.

1.31 “Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг олон улсын конвенц”-д Монгол Улс нэгдэн орсныг соёрхон батлах тухай хууль /2007 он/-ийн 1 дүгээр зүйлд *“Нэгдсэн Үндэстний байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын 2005 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Ерөнхий чуулганы 33 дугаар хуралдаанаар баталсан “Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг олон улсын конвенц”-д Монгол Улс нэгдэн орсныг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай”-гэж баталжээ.*

1.32 Допингийн эсрэг үндэсний төвийн бие даасан байдлын шаардлагын дагуу Монголын Допингийн эсрэг төв 2007 онд үүсгэн байгуулагдсан байна. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд *“Тамирчдыг спортын бэртэл гэмтэл авахаас урьдчилан сэргийлэх, сургалт уулзалт зохион байгуулах, төсөл хөтөлбөр боловсруулах, ижил зорилготой байгууллагуудтай хамтран ажиллах”* гэсэн үйл ажиллагааны чиглэлтэйгээр бүртгэгдсэн нь байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй уялдахгүй байна.

1.33 МҮОХ, БНСУ-ын Шинжлэх ухаан, технологийн институтийн допингийн хяналтын төвийн хооронд 2006 онд харилцан ойлголцлын санамж бичгийг 5 жилийн хугацаатайгаар жилд 100 хүртэлх дээжийн шинжилгээний зардлыг чөлөөлж болохоор тохиролцож байгуулан хэрэгжүүлж ирсэн байна.

1.34 Уг санамж бичгийг 2011 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр дахин 5 жилээр сунгасан нь Дэлхийн допингийн эсрэг дүрмийн 20.4¹⁶-н 20.4.3-т *“Допингийн эсрэг үндэсний байгууллагын өөрийн улсын хэмжээнд бие даасан байдлыг хүндэтгэн үйл ажиллагаа болон шийдвэр гаргалтад нь нөлөөлөхгүй”* гэж заасныг зөрчин Допингийн эсрэг үндэсний төвийн чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

1.35 Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 391¹⁷ дүгээр тогтоолоор допингийн эсрэг үйл ажиллагаанд шаардагдах зардлыг өөрийн төсвийн багцдаа тусгуулах арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдад даалгасан байна.

1.36 Мөн Засгийн газрын 2009 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор *“Олон улсын байгууллага, гэрээ, конвенцын итгэмжит санд төлөх татвар, хандивын тухай” Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 60 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Татварыг нь улсын төсвөөс төлөх олон улсын байгууллагуудын жагсаалт”-д “60. Дэлхийн сэргээшийн эсрэг агентлаг-ЭМЯ” гэж нэмсүгэй”* гэж заажээ.

1.37 Цаашид Допингийн эсрэг үндэсний төв, төр засгийн байгууллагатай хамтран хууль тогтоомжийн хүрээнд “Допингийн эсрэг үндэсний дүрэм”-ийг боловсруулж, батлуулах шаардлагатай байна.

¹⁶ Үндэсний Олимпийн хорооны үүрэг

¹⁷ “Спортод допинг хэрэглэхийн эсрэг олон улсын конвенцийг хэрэгжүүлэхэд зорилгоор улсын хэмжээнд допингийн эсрэг мэдээлэл, сургалт, сурталчилгаа, судалгаа хийх, урьдчилан сэргийлэх, допингийн хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлэн шинжилгээ авах баталгаажуулах, үр дүнг тооцох чиг үүргийг Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхийг зөвшөөрч”

Спортын байгууллага, холбоодтой хамтран ажиллах, дэмжлэг тусалцаа үзүүлэх талаар:

1.38 Зорилго, зорилтынхоо хүрээнд спортын байгууллага, холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг тусалцаа үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж хэвшсэн байна. Тухайлбал,

- Спорт холбоодын үлгэрчилсэн дүрэм, ажил дүгнэх журмыг гүйцэтгэх зөвлөлийн хурлаас баталж гаргасан,
- Спорт холбоодын ЕНБ-ийн дарга, удирдлагуудад семинар, ширээний теннисийн тэмцээн зохион байгуулсан,
- "Спортын холбооны бүтцийг сайжруулах хөтөлбөр"-ийг 2012 онд баталсан,
- Боксын холбоонд тоглолтын бээлий хамгаалах хэрэгсэл,
- Байт харвааны холбоонд хувцас, хэрэгсэл, Жүдо бөхийн холбоонд кимоно өмсгөл хандивласан,
- 2012 онд нийт 13 холбоонд 68.5 сая төгрөг зарцуулсан,
- Теннисний холбоонд 8.0 мянган ам долларыг Олимпийн төрлүүдийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд дэмжлэг тусалцаа үзүүлсэн байна.

1.39 Тамирчдад эрүүл мэндийн тусалцаа үзүүлэх, эрүүл мэндийг сахин хамгаалах зорилгын хүрээнд хэрэгжүүлсэн витамин, мөнгөн тусламж үзүүлэх зэрэг арга хэмжээ нь үр нөлөөтэй хэрэгжиж байна гэж үзэх боломжгүй байна.

1.40 МҮОХ-ны үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар спорт холбоодоос авсан судалгааны үр дүнгээс харахад дараах асуудлуудыг анхаарах зайлшгүй шаардлага бий болсон байна. Үүнд:

- Үндэсний олимпийн хорооны гишүүнчлэлдээ анхаарах, орон нутагт байгаа гишүүдийг бүрэн хамруулах,
- Орон нутгийн олимпийн зөвлөлийн үйл ажиллагаа доголдсон зогсонги байдалд орсон,
- Зарим спортын холбоод ямар ч үйл ажиллагаа явуулдаггүй зөвхөн хурал, зөвлөгөөн сонгуульт ажилд оролцох байдлаар ханддаг,
- Хувь хүн МҮОХ-ны гишүүн байх тодорхой нөхцөлийг Хартид заасны дагуу шийдвэрлэх,
- Олимпийн болон олимпийн бус спортын төрөл хэмээн ялгаварлах хандлагыг арилгах,
- Дүрмээ шинэчлэх, гишүүнчлэлийн асуудлыг шийдвэрлэх, Олимпийн зөвлөлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох,
- ОУ-ын сургалтад ямар шалгуураар хэрхэн хамрагдах мэдээлэл ил тод биш,
- МҮОХ, БТС хороодод бүртгэлтэй гишүүнчлэлийн давхардлыг арилгах.

Эх сурвалж: МҮОХ-ны гишүүнчлэлтэй холбоодоос авсан судалгаа

1.41 Нөгөө талаас үндсэн үйл ажиллагааны хүрээнд үр дүнтэй хэрэгжиж буй дараах арга хэмжээнүүд байна. Үүнд:

- Хөтөлбөр арга хэмжээний хүрээнд тамирчин, дасгалжуулагчдыг сүүлийн үеийн шинжлэх ухаан, техник технологи, арга барилыг сурталчлан таниулах тухай Спорт холбоодын удирдлагуудыг тогтмол сургалтуудад хамруулсан,
- ЕБС-ийн дунд олимпийн үзэл санааг түгээх, дэмжих, зорилгоор танхим байгуулсан,
- Залуу тамирчдад болон дасгалжуулагчдад мөнгөн тэтгэлэг олгосон,
- Залуу судлаачдыг Грекийн олимпийн хороо, академитай хамтарсан сургалтад хамруулсан,
- Сургалт семинарууд нь хот, орон нутгийн дасгалжуулагч, тамирчдыг шинэ мэдлэг мэдээллээр хангадаг байна.

Эх сурвалж: МҮОХ-ны гишүүнчлэлтэй холбоодоос авсан судалгаа

1.42 МҮОХ-ны Дүрмийн 4.10-д "Спортын маркетингийг хөгжүүлэх, санхүүгийн шинэ эх үүсвэр бий болгох, хандивлагчидтай хамтран ажиллах" гэж санхүүгийн эх үүсвэр бий болгох тухай зааж өгсөн байна.

1.43 Энэ хүрээнд спортын маркетингийн талаар хийгдэх ажлын төлөвлөгөөг 2018, 2019 онд гаргасан боловч хэрэгжилт хангалтгүй, спортын хөгжил, тамирчдын амжилтад нөлөөлсөн эсэх нь нотлогдохгүй байна.

1.44 МҮОХ-ны гишүүдийн хурлаар үйл ажиллагааны жилийн тайланг хэлэлцэн хангалттай гэж дүгнэсэн ч хэрэгжилт, үр дүнг үнэлэх шалгуур тодорхойгүй, үнэлгээ бодитой бус байна.

1.45 Төрийн бус байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5¹⁸-д заасны дагуу тухайн байгууллагын үйл ажиллагаа ил тод нээлттэй байх зохицуулалттай ч олон нийт, спортын холбоод, тамирчдад нээлттэй ил тод байх нөхцөлийг бүрдүүлээгүй <https://www.olympic.mn/> цахим хуудаст байршуулсан мэдээлэл хангалтгүй байна.

1.46 Олимп, тив, бүсийн наадамд оролцох тамирчин бэлтгэл, сургуулилт, уралдаан тэмцээн, тоглолтод оролцож байх үедээ бэртэж гэмтэх, амь нас, эрүүл мэндээрээ хохирсон тохиолдолд нөхөн төлбөр олгох даатгал, эрүүл мэнд, тэдний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн спортын даатгалын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

1.47 МҮОХ нь олимпийн наадам, ОУОХ-ны ивээл дор зохиогдох тив дэлхийн спортын олон төрөлт тэмцээнд Монгол Улсыг төлөөлөх онцгой эрхийг Олимпийн Хартийн дагуу эдэлж оролцохоор байгаа ч нөгөө талаар Монгол Улсын хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагыг орхигдуулж болохгүй.

1.48 Түүнчлэн Төрийн бус байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5¹⁹-д заасны дагуу МҮОХ-ны үйл ажиллагаа нийтэд ил тод нээлттэй байх, үндэсний эв нэгдлийг сахин хамгаалах нөхцөл боломжийг бүрдүүлэх, хэрэгцээ шаардлага байна.

БҮЛЭГ 2. МҮОХ-ны хөрөнгө оруулалт, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт, мэдээллийн ил тод байдал хангалтгүй байна.

Орлогын эх үүсвэрийг бодитой төлөвлөөгүй, хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

2.1 Монгол Улсад Олимпийн хөдөлгөөнийг хөгжүүлэх, хамгаалах, сурталчлан дэлгэрүүлэх зорилгоо хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг ОУОХ болон АОЗ-өөс хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, захиргаа аж ахуйн санхүүжилт, гишүүн холбоодын татвар, хувь хүн, хуулийн этгээдийн хандив, бусад орлогоос бүрдүүлэхээр дүрэмд заасан байна.

2.2 МҮОХ нь 2012-2019 онд 479.0-1,789.1 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн ажилласан ба дунджаар 82.6 хувийг гадаад, 17.4 хувийг дотоод үйл ажиллагааны орлого эзэлж байна.

Орлогын эх үүсвэр /сая төгрөгөөр/

Хүснэгт №2

¹⁸ Хуулийн 5.Төрийн бус байгууллагын үйл ажиллагаа нь олон түмэнд ил тод байх ба түүний гишүүд болон иргэд хэн ч тухайн байгууллагын тайлантай танилцаж болно.

¹⁹ Хуулийн 5.5-“Төрийн бус байгууллагын үйл ажиллагаа нь олон түмэнд ил байх ба түүний гишүүд болон иргэд хэн ч тухайн байгууллагын тайлантай танилцаж болно”

Огноо	Гадаад санхүүжилт			Татвар	Хандив	Түрээс	Хамтран ажиллагч		Хүү Валют	Бусад орлого	Нийт орлого
	ОУОХ	АОЗ	Лондон ЗБХ				Түншлэл	Төр			
2012	657.7	99.7	179.5	0.4	14.4	30.0	12.7	200.0	1.8	144.2	1,340.4
2013	285.0	135.5	-	0.4	-	28.8	20.0	4.3	0.5	4.5	479.0
2014	451.4	408.1	-	0.5	-	36.5	63.0	162.0	1.0	5.3	1,127.7
2015	731.7	224.1	-	1.2	-	37.6	-	-	1.2	13.3	1,009.1
2016	1,495.6	183.8	-	0.9	-	36.9	33.0	28.4	0.6	9.8	1,789.1
2017	630.5	345.6	-	6.6	-	40.5	30.0	65.9	17.7	93.0	1,229.8
2018	750.4	332.6	-	1.2	-	32.6	50.0	226.6	14.0	103.3	1,510.7
2019	805.0	343.3	-	3.6	-	51.4	92.5	-	7.1	13.5	1,316.5

Эх сурвалж: МҮОХ-ны санхүүгийн тайлан, дансны хуулга

2.3 Гадаад эх үүсвэрийн төлөвлөгөөг төрөл тус бүрээр төлөвлөдөггүй, орлогын эх үүсвэрийг бодитой тооцож батлуулдаггүйгээс 88.4-204.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Графикаар харуулбал:

Гадаад эх үүсвэр 2012-2019 он /ам.доллар/

Дүрслэл 2



Эх сурвалж: МҮОХ-ны санхүүгийн тайлан, дансны хуулга

2.4 Дотоод үйл ажиллагааны хүрээнд гишүүн холбооны татвар, түрээс, түншлэлээс орлого бүрдүүлэхээр төлөвлөн батлуулсан бөгөөд гүйцэтгэл 45.5-135.3 хувийн гүйцэтгэлтэй байна. /Хавсралт 1/

2.5 МҮОХ-ны 22 гишүүн спортын холбоод 2012-2019 онд 15.4 сая төгрөгийн гишүүнчлэлийн татварыг төлөөгүй байгаа нь МҮОХ-ны дүрмийн 6.1.5²⁰-д заасныг зөрчсөн байна.

2.6 МҮОХ 504 м² талбай бүхий 27 ажлын өрөөг 25 спортын холбоонд түрээслүүлдэг ч орлогыг бүрэн бүрдүүлээгүй байна. Тухайлбал:

- Түрээсийн орлогын төлөвлөгөө болон гүйцэтгэлийг 2019 оны байдлаар авч үзэхэд 12.0 сая төгрөгөөр орлогыг дутуу төлөвлөсөн;
- Нэр бүхий 7 спортын холбоо түрээсийн төлбөр 12.1 сая төгрөгийг төлөөгүй гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаагүй;
- Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийн хурлын 2015 оны “Аж ахуйн үйл ажиллагаа явуулах” 09 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй;

²⁰ МҮОХ-ны дүрмийн 6.1.5 МҮОХ-ны Гишүүдийн хурлаас тогтоосон МҮОХ-ны гишүүнчлэлийн татварыг тухай бүрд нь төлдөг байх.

2.7 МҮОХ нь дүрмийн 4.15-д заасан Олимпийн тэмдэг, туг, уриа, сүлд, дуулал, таних тэмдэг, бэлгэдэл, галт бамбарыг ашиглан спортын маркетинг хөгжүүлэхэд санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх боломжийг бүрэн ашиглаагүй байна. Тухайлбал:

- Аудитын хамрах хугацаанд зөвхөн 2012 онд Лондонгийн олимпийн наадамд оролцохоор 14.4 сая төгрөгийн хандивын орлого бүрдүүлж, зарцуулсан;
- МҮОХ-ны Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийн хурлаар түншлэлийн орлогыг 2015 онд 40.0 сая, 2019 онд 200.0 сая төгрөгөөр төлөвлөж, бусад онд төлөвлөөгүй бөгөөд 2012-2019 онд 12.7-92.5 сая төгрөгийг бүрдүүлсэн.

МҮОХ-ны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт, сахилга, хариуцлага дутагдаж байна.

2.8 МҮОХ-ны жилийн төсвийг 2012-2016 онд Гүйцэтгэх зөвлөлийн хурлаар, 2017, 2018 онд Гишүүдийн хурлаар тус тус баталсан бөгөөд 2019 онд төсвөө батлаагүй байна. Гүйцэтгэх зөвлөлийн 2012 оны хурлын 1 дүгээр тогтоолоор төсөв баталсан ч хуваарийг хавсаргаагүй байна.

2.9 МҮОХ-ны төсөв, гүйцэтгэлийг 8 жилээр авч үзэхэд 2013 онд 81.3 сая төгрөгийг дутуу зарцуулж, 2014-2018 онуудад батлагдсан төсвийг 6.6-474.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. /Хавсралт 1/

2.10 Гишүүдийн хурлаар жилийн төсвийг хэлэлцэн батлахаар заасан ч гүйцэтгэлийг хэлэлцэх зохицуулалтгүйгээс санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтын үр нөлөө алдагдаж төсөв хэтрэх, анхан шатны баримтгүй, төсөвт тусгагдаагүй зардал гарах нөхцөл бүрджээ.

2.11 Жилийн төсөв батлалгүйгээр 2012, 2019 онд 2,395.1 сая төгрөгийг зарцуулсан, батлагдсан төсвийг 1,298.8 сая төгрөгөөр хэтрүүлсэн, төсөвт тусгаагүй 125.2 сая төгрөгийг зарцуулсан байна. /Хавсралт 3/

2.12 Тушаал шийдвэргүй, гэрээ хэлцэл, гүйцэтгэлийн тайлангүй, албан томилолтоор ажилласныг нотлох баримтгүй зэрэг анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй нийт 1,938.3 сая төгрөгийн ажил гүйлгээ хийсэн байна. /Хавсралт 2/

2.13 Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1²¹, 79 дүгээр зүйлийн 79.1²²-д заасныг хэрэгжүүлээгүй ихэнх ажилтны ээлжийн амралтын олговрыг тооцож олгодоггүй, биеэр эдлүүлдэггүй байна.

2.14 Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийн хурлын 2017 оны 04 дүгээр тогтоолоор баталсан МҮОХ-ны “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7 дугаар хэсгийн 7.3²³, 7.4²⁴-ыг зөрчин ажилтнуудын ажлын үр дүнг үнэлэлгүйгээр урамшуулал олгож байна.

2.15 Засгийн газрын 2012 оны 128 дугаар тогтоолын дагуу тамирчдын хүч чадлыг нэмэгдүүлэх үйлчилгээтэй нэмэлт бүтээгдэхүүн авахад зориулж Соёл, Спорт, Аялал жуулчлалын яамнаас /хуучнаар/ 200.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байх

²¹ Хуулийн 55.1-д “Ажилтанд ээлжийн амралтын хугацаанд ээлжийн амралтын олговор олгоно”

²² Хуулийн 79.1-д Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. ...”

²³ ХДЖ-ын 7.3. Ажил олгогч, түүний төлөөлөгч нь ажилтны ажлын байрны тодорхойлолт дахь ажил, үүргийн дагуу ажлын үр дүнг хагас жил, жилээр ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэнэ.

²⁴ ХДЖ-ын 7.4. Журмын 7.3-т заасан ажлын үр дүнгийн үзүүлэлт нь ажилтанд нэмэгдэл хөлс, шагнал, урамшуулал олгох болон энэ журам, хөдөлмөрийн гэрээнд заасан хариуцлага тооцох үндэслэл болно. Жилийн эцэст ажилтан албан тушаалтнуудын ажлыг үнэлж дүгнэлгүйгээр, үндэслэлгүйгээр урамшуулал бодож олгодог байна.

бөгөөд бүтээгдэхүүнийг орлого авч, зарцуулсан нотлох баримтгүй, төрөөс олгосон хөрөнгийн зарцуулалтыг тайлагнаагүй зөрчил илэрлээ.Тодруулбал:

- Уламжлалт анагаах ухаан, оюун санааны хөгжил санд 100.0 сая, Тамирчин нөхөн сэргээх сувилал ХХК-д 19.8 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн,
- Нягтлан бодогч Л.Жаргал Ч-0330541 дугаарын чекээр 80.0 сая, Ч-0240999 чекээр 0.2 сая төгрөгийг бэлнээр авсан боловч 80.0 сая төгрөгийг кассад орлого аваагүй, зарцуулалт тодорхойгүй.

Хөрөнгө ашиглах, зарцуулахад гаргасан зарим шийдвэр нь МҮОХ-ны эрх ашигт нийцэхгүй байна.

2.16 МҮОХ нь 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 739.3 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй бөгөөд дараах үндсэн хөрөнгө, бараа материалд тооллого хийж, гишүүдийн хуралд танилцуулжээ. Үүнд:

- 3000 м2 талбай бүхий 485.4 сая төгрөгийн өртөг бүхий конторын барилга,
- 161.0 сая төгрөгийн 3 авто машин,
- 44.4 сая төгрөгийн 382 тавилга,
- 48.5 сая төгрөгийн 65 тоног төхөөрөмж.

2.17 МҮОХ нь өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 33.0 сая төгрөгийн Бөртэ-чоно хөшөө, 14.5 сая төгрөгийн олимпийн таван цагариг, 37.5 мянган ам.доллар буюу 73.7 сая төгрөгийн олимпийн цогцолбор, 5.3 сая төгрөгийн камер, Төрийн байгууллагаас шилжүүлэн авсан 7.9 сая төгрөгийн халаалтын цогц төхөөрөмж, зэрэг нийт 134.4 сая төгрөгийн хөрөнгийг орлого авч бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг зөрчиж байна.

2.18 МҮОХ 2004 онд нийт 67720 м² эзэмшил газартай байснаас Нийслэлийн Засаг даргын 5 удаагийн захирамжаар өөрчлөлт орж, 3666 м² газар үлдсэн байна.

Газрын эзэмшилд орсон өөрчлөлт /м2/

Хүснэгт №3

Д/д	Огноо дугаар	Захирамжийн утга	Эзэмших хугацаа /жилээр/	Шилжүүлсэн талбай	МҮОХ-ны эзэмшил газар	Шинээр эзэмшигч
1	2004.10.06 №455	Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг баталгаажуулах тухай	15		67720	МҮОХ
2	2008.08.25 №379	Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нэр шилжүүлэх тухай	15	3600	64120	Нийслэл өргөө ХК
3	2011.04.21 №340	Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн талбай, зориулалт, байршил өөрчлөх тухай	5	27632	36488	НЗД-ын шийдвэрээр өөрчилсөн.
4	2012.06.13 №А/420	Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нэр шилжүүлэх тухай	5	11678	3666	Монголын Бэйсболын үндэсний холбоо ТББ
			5	14156		Монголын Регбигийн холбоо ТББ
			5	4017		Олимп сургалтын төв ТББ
			5	2971		Тамирчин нөхөн сэргээх сувилал ХХК
5	2018.08.22 №А/745	Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний хугацааг сунгах	15		3666	МҮОХ

Эх сурвалж: Нийслэлийн газар зохион байгуулалтын албанаас ирүүлсэн мэдээлэл

2.19 Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 01 дүгээр сарын 27-ны 173 дугаар шийтгэх тогтоолоор “МҮОХ-ны эзэмшлийн газраас 30*20 метрийн харьцаатай газрыг “Нийслэл Өргөө” ХК-ийн нэр дээр шилжүүлсэн холбогдох заалтыг хүчингүй болгож 3600 м² газрыг Монголын Үндэсний Олимпийн Хороонд шилжүүлсүгэй” гэсэн шийдвэр гарч, хэрэгжсэн байна.

2.20 Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийн хурлын 2012 оны 4 дүгээр тогтоолоор 28445 м² газрыг 2 гишүүн холбоо, Олимп сургалтын төв, Тамирчин нөхөн сэргээх сувилал ХХК-д өгөхөөр шийдвэрлэснийг МҮОХ-ны ерөнхийлөгч 2012 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 1/34 дугаартай “Газар шилжүүлэх тухай” албан хүсэлтийг Нийслэлийн газрын албанд хүргүүлэхдээ газрын нэгж талбарыг 10000 м²-р нэмсэн, НЗД-аас хүсэлтийг шийдвэрлэхдээ 6535 м² талбайг бууруулж, 912 м² талбайг нэмж 420 дугаар захирамж гаргажээ.

Газрын эзэмшилд орсон өөрчлөлтийн зөрүү

Хүснэгт №4

д/д	Газар эзэмшигч	ГЗГ-ийн хурлын 2012 оны 4 дүгээр тогтоолоор	Ерөнхийлөгчийн 2012.04.10-ны өдрийн 1/34 албан тоотой НГЗБА-нд хүргүүлсэн	Зөрүү	НЗД-ийн захирамжаар	Зөрүү
1	Монголын Бэйсболын үндэсний холбоо	11678 м ²	11678 м ²	-	11678 м ²	
2	Монголын Регбигийн холбоо	9467 м ²	19467 м ²	10000 м ²	14156 м ²	- 5311 м ²
3	Олимп сургалтын төв	3105 м ²	3105 м ²	-	4017 м ²	912 м ²
4	Тамирчин нөхөн сэргээх сувилал ХХК	4195 м ²	4195 м ²	-	2971 м ²	-1224 м ²
Нийт		28445 м²	38445 м²	10000 м²	32822 м²	-5623 м²

Эх сурвалж: Нийслэлийн газар зохион байгуулалтын албанаас ирүүлсэн мэдээлэл

2.21 ТББТХ-д заасан удирдах зөвлөл буюу МҮОХ-ны гишүүдийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэлгүйгээр хөрөнгө, барилга, байгууламж барих, шилжүүлэхтэй холбоотой дараах шийдвэрүүдийг гаргасан нь итгэл эвдэж, эрх мэдлээ хэтрүүлсэн байж болзошгүй нөхцөл байдал үүссэн байна. Үүнд:

- ГЗГХ-ын 2004 оны 11 дүгээр сарын 26-ны 09 дүгээр тогтоолоор МҮОХ-ны ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор орон сууцны барилга барих зөвшөөрөл олгохоор;
- ГЗГХ-ын 2005 оны 7 дугаар сарын 01-ний 4 дүгээр тогтоолоор Б.Наранцэцэгт тамирчдад зориулсан нөхөн сэргээхтийн төв барьж байгуулах зээл авахад дэмжлэг үзүүлэхээр;
- ГЗГХ-ын 2007 оны 9 дүгээр сарын 17-ны 9 дүгээр тогтоолоор Тамирчдын сэргээхтийн төвийн барилгыг 2004 онд эхлүүлсэн ба барилгыг яаралтай ашиглалтад оруулах, үүнтэй холбогдуулан санхүүгийн асуудлыг олон улсын төсөл хэрэгжүүлэх, банкнаас зээл авах, түнш байгууллагаас дэмжлэг авах, аж ахуй нэгжүүдтэй хамтран шийдвэрлэх;
- ГЗГХ-ын 2008 оны 11 дүгээр сарын 13-ны 17 дугаар тогтоолоор Тамирчин нөхөн сэргээх сувиллын барилгыг Тамирчин нөхөн сэргээх сувилал ХХК-д шилжүүлэх;
- 56.1 сая төгрөгийн дансны үнэтэй 9-25 жил ашигласан 3 автомашиныг /Ланос суудлын машин УК 63-13, Самосваль ачааны машин УБМ 63-20, Ниссан патрол жил УБГ 31-99/ актлаад 19.0-22.0 сая төгрөгөөр зарж борлуулах тухай 2012 оны 02 сарын 01-ний 08 дугаар тушаал гарган, зарж борлуулсан.

2.22 МҮОХ ажилчдын 40 айлын орон сууцны барилга барих хөрөнгийн эх үүсвэрийг Голомт банкнаас МҮОХ-ны нэр дээр гаргуулан авч бариулсан бөгөөд орон сууцны борлуулалтын орлогоос 23.0 сая төгрөгийг Тамирчин нөхөн сэргээх сувиллын барилга барихад зарцуулсан баримт зэргээс үзэхэд тус 2 барилгыг барих хөрөнгийн эх үүсвэр бий болгоход МҮОХ-ны нэр хүндийг ашиглан хөрөнгө бий болгосон, МҮОХ-ны бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэлгүй

Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийн хурлын 2008 оны 11 дүгээр сарын 13-ны 17 дугаар тогтоолоор Тамирчин нөхөн сэргээх сувиллын барилгыг Тамирчин нөхөн сэргээх сувилал ХХК-д шилжүүлсэн зэрэг нь урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан байж болзошгүй байна.

2.23 Мөн МҮОХ-ны ажилтан Б.Наранцэцэгийн хүсэлтийг үндэслэн тамирчдад зориулсан нөхөн сэргэлтийн төв барихад Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийн хурлын 2005 оны “Зээл авахад дэмжлэг үзүүлэх тухай” 04 тоот тогтоолоор дэмжлэг үзүүлэн арилжааны банкнаас зээл авахад баталгаа гаргаж өгсөн, мөн 2008 оны 17 дугаар тогтоолоор Тамирчин нөхөн сэргээх сувилал ХХК-ийн өөрийн хөрөнгөөр барьсан барилгыг шилжүүлэхийг зөвшөөрсөн тухай шийдвэрүүд нь Төрийн бус байгууллагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн байна.

2.24 Дээрх асуудалтай холбоотой 2013 онд МҮОХ-ны ерөнхийлөгч /асан/ Д.Загдсүрэн, Захиргааны дарга, хуулийн зөвлөхөөр ажиллаж байсан Б.Наранцэцэг нарыг *бүлэглэн, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж, ашиг, хонжоо олох зорилгоор МҮОХ-ны өмчлөлд байсан газар, байшин барилгатай холбоотойгоор эрүүгийн гэмт хэрэгт холбогдуулан шалгаж 2014 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр 173 дугаар шийтгэх тогтоолоор шийдвэрлэж байсан ч тухайн үед шийдвэр гаргахад оролцсон бусад гишүүдийн гэм буруугийн асуудал хөндөгдөөгүй байна.*

2.25 Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийн хурлын 2012 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр 4 дүгээр тогтоолоор МҮОХ-ны эзэмшил газраас бусдад шилжүүлсэн асуудлыг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэх нь зүйтэй байна.

2.26 МҮОХ-ны нэр дээр арилжааны 2 банкны 4 дансаар дамжуулан 1,760.7 сая төгрөгийн зээл авч, 360.3 сая төгрөгийг зээлийн хүүд төлж нийт 2,121.0 сая төгрөгийн гүйлгээ хийснийг МҮОХ-ны санхүүгийн бүртгэл, тайланд тусгаагүй байна.

Арилжааны банкнаас авсан зээл, хүүгийн төлбөр /сая төгрөгөөр/ Хүснэгт №5

Дансны нэр, дугаар	Зээлийн дүн	Хүүгийн зардал	Дүн
Улаанбаатар банк /валют данс/ 2612017449 /МҮОХороо/	837.9	198.7	1,036.6
Голомт банкны данс 9211011227 /МҮОХороо/	150.0	28.8	178.8
Голомт банкны данс 9211011227 /МҮОХороо/	500.0	112.4	612.4
Голомт банкны данс 8111002058 /МҮОХороо/	250.0	19.0	269.0
Голомт банкны данс /валют / 9221010723 /МҮОХороо/	22.8	1.4	24.2
Нийт дүн	1,760.7	360.3	2,121.0

Эх сурвалж: МҮОХ-ны арилжааны банк дахь дансны хууль

МҮОХ санхүүгийн үйл ажиллагаандаа НББ-ийн бодлогын баримт бичиг боловсруулан батлуулж мөрдөөгүй байна.

2.27 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2²⁵-т заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан батлуулж, мөрдөөгүй байна.

²⁵ Хуулийн 18.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.

2.28 МҮОХ нь нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллага бөгөөд нийт хөрөнгө буурснаас бусад санхүүгийн үзүүлэлтүүд харьцангуй тогтвортой байна. Хүснэгтээр харуулбал:

Санхүүгийн үзүүлэлтүүд 2012-2019 он /сая төгрөгөөр/

Хүснэгт №6

Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
Мөнгөн хөрөнгө	284.4	66.5	103.2	137.3	503.7	252.3	193.6	367.4
Авлага	14.6		10.0	4.9		0.1		
Урьдчилж төлсөн зардал			0.3		0.3			
Бараа материал	58.9	51.1	61.5	68.0	91.4	87.3	86.9	99.4
Үндсэн хөрөнгө	657.8	686.7	653.4	631.4	631.1	594.4	490.0	450.0
Нийт хөрөнгийн дүн	1,015.7	804.3	828.4	841.6	1,226.5	934.1	770.5	916.8
Богино хугацаат өр төлбөр	144.3	7.2	1.2	37.0	20.4			
Эзэмшигчдийн өмч	655.6	655.6	655.6	655.6	655.6	655.6	655.6	655.6
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	226.2	169.0	189.2	153.9	548.9	548.9	548.9	548.9
Тайлант үеийн ашиг алдагдал	(1.4)	(206.8)	(95.8)	(4.9)	1.6	(272.0)	(163.6)	146.3
Өмнөх үеийн ашиг алдагдал	(9.0)	179.3	78.2			1.6	(270.4)	(434.0)
Нийт өр төлбөр эзэмшигчдийн дүн	1,015.7	804.3	828.4	841.6	1,226.5	934.1	770.5	916.8

Эх сурвалж: МҮОХ-ны 2012-2019 оны санхүүгийн тайлан

2.29 МҮОХ нь 2017 оноос Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн санхүү бүртгэлийн “Leader”, цалингийн “Payroll” программуудыг ашиглаж эхэлснээр 2012-2016 онуудад гарч байсан санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, тодруулга, орлого, зарлага зөрүүтэй тайлагнадаг алдаа дахин гараагүй байна. Хүснэгтээр харуулбал:

Санхүүгийн тайлан дахь зөрүүтэй илэрхийлэл 2012-2016 он

Хүснэгт №7

/сая төгрөг/

д/д	Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	Дүн
1	Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Санхүүгийн болон Мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад зөрүүтэй тайлагнасан	73.6	-0.3	0.7	0.03	1.0	75.0
2	Мөнгөн гүйлгээний тайланд мөнгөний орох, гарах урсгалыг дутуу тайлагнасан	211.4	97.7	546.5	39.9	49.1	944.5
3	Тайлант үеийн үр дүнг Санхүүгийн байдал, Өмчийн өөрчлөлтийн тайланд зөрүүтэй тайлагнасан	-28.4	46.2	105.6			123.4
	Дүн	256.4	143.6	652.8	39.9	50.1	1,142.9

Эх сурвалж: МҮОХ-ны 2012-2019 оны санхүүгийн тайлан, дансны хуулга

2.30 Мөн 189.3 сая төгрөгийн хувцас хэрэглэл, аж ахуйн материалыг орлого авч, зарцуулаагүй, шууд зардлаар бүртгэсэн нь НББОУС-2 “Бараа материал” стандартыг зөрчжээ. /Хавсралт 3/

2.31 Гадаад валютын ханшийн зөрүүгээс олсон ашгийг Орлого үр дүнгийн тайланд тусгаагүй тохиргоо бичилтээр Эзэмшигчийн өмчийн бусад хэсэгт тайлагнаж байсан нь Сангийн сайдын 2017 оны 386 тоот тушаалаар баталсан төрийн бус байгууллагад мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн дансны нэгдсэн жагсаалт”, Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)-ыг бүртгэх НББОУС 21 стандарттай нийцээгүй байна.

2.32 Хэдийгээр нягтлан бодох бүртгэлийн дээрх алдааг залруулсан ч цаашид залруулах шаардлагатай өглөг, авлага дутуу бүртгэсэн, урьдчилж төлсөн төлбөрийг тооцоо үүсгэлгүй шууд зардлаар бүртгэсэн, бэлнээр авсан мөнгөн гүйлгээнд кассын тайлан гаргадаггүй, олимпийн наадамд оролцох тамирчдад зориулж дэмжлэгт өгсөн хувцас, хэрэглэлийг орлого авч, шилжүүлдэггүй зэрэг алдаа, зөрчил байна.

2.33 Урьдчилж төлсөн нийт 128.7 сая төгрөгийн төлбөрийг хоорондын тооцоо үүсгээгүй, шууд зардлаар бүртгэсэн нь хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сулруулж байна. Тухайлбал:

- Япон улсын Токио хотноо болох зуны 32-р олимпд оролцох төлөөлөгчдийн зочид буудлын төлбөр нийт 57.1 сая төгрөгийг урьдчилан шилжүүлснийг тооцоо үүсгэж, урьдчилж төлсөн зардлаар бүртгээгүй,
- МҮОХ-ны анхны ерөнхийлөгч Э.Дарьсүрэнгийн цээж баримал хийлгэхээр 2018 оны 4 дүгээр сарын 10-д иргэн Д.Санчирт 2.0 сая төгрөг шилжүүлснийг авлагаар тусгаагүй, өнөөг хүртэл ажил нь хэрэгжээгүй,
- Иргэн Э.Мөнх-Очирын нэхэмжлэлтэй холбогдох иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх зүйн үйлчилгээ авах гэрээ байгуулж, 18.1 сая төгрөгийг 2019 оны 1, 7 дугаар саруудад шилжүүлсэн бөгөөд авлага үүсгээгүй шууд зардлаар бүртгэсэн,
- Бусад 51.5 сая төгрөгийн урьдчилж төлсөн төлбөрийг бүртгээгүй зөрчлийг 2012-2014 онуудад гаргасныг залруулсан байна..

2.34 МҮОХ нь 2012-2019 онуудад нийт 282.2 сая төгрөгийн бэлэн мөнгөний гүйлгээнд кассын тайлан гаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3²⁶-т заасныг зөрчсөн байна. /Хавсралт 3/

2.35 Монголын баг тамирчдыг тив, бүсийн наадамд оролцоход нь олон улсын байгууллага, хуулийн этгээдээс хувцас хэрэглэлийн дэмжлэг олгодог бөгөөд МҮОХ бүртгэл тайланд тусгадаггүй байна. Тухайлбал 2017 онд Азийн наадамд оролцоход БНХАУ-ын “361⁰” спорт брэндээс хувцас хэрэглэл дэмжлэг болгосныг МҮОХ хүлээн авч, тамирчдад олгосон талаар бүртгэл тайланд тусгаагүй байна.

2.36 МҮОХ нь санхүүгийн жилийн тайлангаа 2015 оноос эхлэн “E-balance” программаар харилцагч байгууллагад илгээсэн бөгөөд хувь хүний орлогын, үл хөдлөх эд хөрөнгийн, агаарын бохирдлын, авто тээврийн хэрэгслийн албан татварын болон нийгмийн даатгалын тайлангуудыг хуульд заасны дагуу тухай бүр гаргаж, хүргүүлсэн байна.

Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн ашиглалт, зарцуулалт үр дүнг тооцох шалгуур үзүүлэлт хангалтгүй байна.

2.37 МҮОХ дүрмийн 28.1-д зорилго, зорилтоо хэрэгжүүлэхийн тулд Хартид нийцүүлэн санхүүгийн эх үүсвэрийн бүрдлийг тодорхойлсон бол ТББТХ-ийн 19-д санхүүгийн эх үүсвэрийн талаар дараах байдлаар тус тус зохицуулсан байна. Үүнд:

²⁶ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах

МҮОХ-ны дүрмийн 28 дугаар хэсэгт зааснаар

- ОУОХ, гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүсээс МҮОХ-нд хандивласан техник, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хэрэглэл материал, эд агуурс, үндэсний болон гадаад валют,
- Олимпийн хөдөлгөөнд зориулж өөрийн хөрөнгөөр бий болгосон барилга байгууламж, музей, номын сан гэх мэт,
- Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас орсон орлого,
- Үйл ажиллагааны явцад бүрдсэн архивын материал, олон улсын спортын байгууллагын баримт бичиг,
- МҮОХ-ны гишүүн байгууллагын элсэлтийн ба жилийн татвар,
- Бусад орлого


ТББТХ-ийн 19 дүгээр зүйлд зааснаар

- 1/ гишүүний татвар, хандив;
- 2/ иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив;
- 3/ дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого;
- 4/ зээлийн, өвийн болон төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгө;

2.38 МҮОХ-ны Санхүүжилтийг 2018, 2019 оны байдлаар авч үзэхэд 37.6 хувийг ОУЭСН-ийн хөтөлбөр буюу тамирчин, дасгалжуулагчдын тэтгэлэг, сургалтад, 9.4 хувийг спорт холбоодыг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан байна.

2018-2019 оны зардлын гүйцэтгэл /төрлөөр/

Дүрслэл №3




Эх сурвалж: МҮОХ-ны 2018-2019 оны санхүүгийн тайлан

2.39 МҮОХ-ны зорилгын хүрээнд олимпизмыг түгээн дэлгэрүүлэх, олимпийн төрлийн спорт холбоодыг дэмжихэд чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгаа нь хөрөнгийн зарцуулалтаас харагдаж байна.

2018-2019 оны зардлын гүйцэтгэл /хувиар/

Дүрслэл №4



Эх сурвалж: МҮОХ-ны 2018-2019 оны санхүүгийн тайлан

2.40 МҮОХ-ны үйл ажиллагаанд зөрчил илэрсэн тохиолдолд ХШЗ нь эрх хэмжээнийхээ хүрээнд бүх гишүүдийн хуралд мэдээлэх үүргээ хангалттай хэрэгжүүлсэн гэж үзэхээргүй байна

2.41 МҮОХ-ны дүрмийн 4.9²⁷-д заасны дагуу ОУЭСН-ээс олимпизмыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, дэмжих хүрээнд хөтөлбөр арга хэмжээнд тамирчид дасгалжуулагчдыг дараах байдлаар хамруулдаг байна.

Хөтөлбөрт хамруулах үе шат

Дүрслэл №5



2.42 ОУЭСН, АОС-аас хэрэгжүүлж буй тэтгэлэгт хөтөлбөрт тамирчдыг тасралтгүй хамруулан, жил бүр санхүүжилт авч байгаа хэдий ч зарцуулалтад тавих хяналт сул, хөтөлбөр хэрэгжүүлэх баримт бичгийг эх хэлнээ хөрвүүлдэггүй, тамирчид дасгалжуулагчдын хүсэл зоригоо илэрхийлэх эрх хязгаарлагдмал, үр дүнг тооцдоггүй байна.

Хөтөлбөрийн санхүүжилт 2012-2019 он

Дүрслэл №6




Эх сурвалж: МҮОХ-ны 2012-2019 оны санхүүгийн тайлан

2.43 Монгол Улс өвөл, зуны Олимпийн наадмаас нийт 26 медаль хүртсэнийг хүн амын тоотой харьцуулж үзэхэд жигд биш амжилтыг үзүүлж байгааг дараах графикаар харуулж байна.

Олимпийн наадмын амжилт, олон улсад эзлэх зэрэглэл

Дүрслэл №7

²⁷ Дүрмийн 4.9. Олимпийн эв нэгдлийн сангийн хөтөлбөрт хамрагдах, туслалцаа авах



Эх сурвалж: МҮОХ-ны үйл ажиллагааны тайлан


2.44 Монгол Улсыг төлөөлсөн баг тамирчдын амжилтыг ахиулан бататгахын тулд спортын шинжлэх ухааны ололт амжилтыг нэвтрүүлэх, судалгаа шинжилгээний ажлыг сайжруулах хэрэгцээ шаардлага бий болсон байна

2.45 МҮОХ-нь олимпийн наадамд оролцох эрх олж авах шалгуур, нөхцөлийг бүрдүүлэх, тамирчны эрүүл мэнд, бэлтгэл сургуулилт зэрэгт спорт холбоод, бусад байгууллагатай хамтын ажиллагаа хангалтгүй, хөтөлбөрт хамруулах хүрээнээс хэтэрдэггүй байна.

2.46 МҮОХ-нь 2013 онд “МҮОХ-ны хөрөнгө оруулалтын бодлого”-оор стратеги төлөвлөгөөг боловсруулан “Олимпийн түнш” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байна.

“Олимпийн түнш” хөтөлбөрийн орлого

Дүрслэл №8



Эх сурвалж: МҮОХ-ны 2012-2019 оны санхүүгийн тайлан

2.47 Дүрмийн 4.10²⁸-т заасны дагуу спортын маркетингийг хөгжүүлэх, санхүүгийн шинэ эх үүсвэр бий болгох зорилгоор гишүүдийн татвар, түрээсийн орлогоос гадна “Түншлэлийн гэрээ”-ээр санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлдэг байна.

2.48 “Олимпийн түнш” хөтөлбөрийн хүрээнд Олимпийн наадамд оролцох баг, тамирчдын бэлтгэлд бодитой хөрөнгө оруулалтаар дэмжлэг авах, Үндэсний спорт холбоодод дэмжлэг үзүүлэх, маркетингийн тогтвортой бодлогыг хангах зэрэг зорилго дэвшүүлсэн байна.

2.49 Гэвч дотоод эх үүсвэрээс оруулж байгаа хөрөнгө оруулалт, тусламж дэмжлэгийг хэрхэн зарцуулсан тухай түншлэгч байгууллага, дэмжигч олон нийтэд тайлагнах асуудал мэдээллийн ил тод байдлыг хангахгүй байгаа нь байгууллагын стратеги төлөвлөгөө, “Олимпийн түнш” хөтөлбөр үр дүнгүй болох эрсдэлтэй байна.

²⁸ Дүрмийн 4.10-д Спортын маркетингийг хөгжүүлэх, санхүүгийн шинэ эх үүсвэр бий болгох, хандивлагчидтай хамтран ажиллах,

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- МҮОХ-ны бүтэц, үйл ажиллагаа нь өөрийн зорилгын хүрээнд нийгэмд үйлчилдэг ТББ-ын шинжтэй бөгөөд өөрийгөө магадлан итгэмжлэх /*гишүүн холбоод*/ тогтолцоог хэрэгжүүлж, биеийн тамир спортын салбарын хөгжлийг дэмжих, өөрийгөө зохицуулах, хянах механизмыг бүрдүүлдгээрээ гишүүддээ үйлчилдэг ТББ-ын ангиллаас ялгаатай байна.
- МҮОХ-нь нийгмийн тусын тулд үйл ажиллагаа явуулах, Монгол Улсыг Олон Улсын Олимпийн хороонд төлөөлөх онцгой эрхтэй байгууллага болохын хувьд Төрийн бус байгууллагын тухай хуульд заасны дагуу гишүүн холбоодын төлөөллийн шийдвэрээр бүртгүүлэхээр заасан ч улсын бүртгэлд 100 хувийн хувьцаа эзэмшигч үүсгэн байгуулагчаар нэг гишүүн /иргэн Д.Загдсүрэн/ бүртгэлтэй байгаа нь хууль зүйн хувьд зөрчилтэй байна.
- МҮОХ-ны дүрэмд гишүүн байгууллагын эрх бүхий этгээд нь сонгуульт ажил, үүргээс огцрох эсвэл татгалзах тохиолдлыг тодорхой тусгаагүйгээс холбоонд хамааралгүй болсон этгээд хуралд оролцох нөхцөл бүрдэж, эрх бүхий гишүүний төлөөлөл хязгаарлагдаж, Олимпийн бус төрлийн спорт холбоодоос чуулган ба гишүүдийн хурлын олонхыг бүрдүүлж байгаа нь Олимпийн Хартийн зарчмыг алдагдуулж байна.
- МҮОХ-ны хөрөнгө захиран зарцуулах шийдвэр, хамтын ажиллагааны хүрээнд байгуулсан гэрээ, хэлцэл, эрх зүйн актыг хуулийн хүрээнд байгуулдаггүй, биелэлтийг дүгнэдэггүй, хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт нэн хангалтгүй байна.
- МҮОХ-ны санхүүгийн үйл ажиллагааны эх үүсвэрийг гишүүн холбоодын татвар, түрээс, түншлэл, бусад орлогоос бүрдүүлэх нөөц бололцоог бүрэн ашигладаггүй байна.
- Хянан шалгах зөвлөл нь МҮОХ-ны ажлын алба, архив, бичиг хэрэг, санхүүгийн үйл ажиллагаанд голлон хяналт хийж, бусад чиг үүргийн хэрэгжилтийг орхигдуулсан байна.
- Хууль тогтоомжид зааснаар ТББ нь үйл ажиллагааныхаа талаар гишүүд, дэмжигчид, олон нийтэд нээлттэй, ил тод байх онцлогтой боловч зөвхөн шагнал урамшуулал бүхий онцлох үйл явдлыг түгээж, бусад үйл ажиллагааны талаар мэдээлэх үйл явц хангалтгүйгээс зарим тохиолдолд ойлголтын зөрүү үүсгэж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд хүндрэл бэрхшээл учруулж байна.
- ОУЭСН, АОХ-оос хэрэгжүүлж буй тэтгэлэгт хөтөлбөрийн арга хэмжээнд тамирчид, дасгалжуулагчийг жигд хамруулахыг эрмэлздэггүй, хөтөлбөрийн санхүүжилтийн зарцуулалт гишүүн холбоодод нээлттэй ил тод биш, хяналт сул байгаа нь спортын салбарын бүлэг давхаргын хүрээнд маргаан бүхий асуудал дагуулдаг байна.

Зөвлөмж

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

МҮОХ-ны Ерөнхийлөгч /Н.Түвшинбаяр/-д

- Байгууллагын үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн асуудлыг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, Төрийн бус байгууллагын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нийцүүлэн шинэчлэн бүртгүүлэх;
- МҮОХ-ны гишүүнчлэлийг Олимпийн Харти болон дүрмийн дагуу бүрдүүлж, ОУОХ-ны 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн зөвлөмжийг хэрэгжүүлж нэмэлт, өөрчлөлтийг бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн ОУОХ-оор баталгаажуулан үйл ажиллагаандаа мөрдөх;
- Төрийн бус байгууллагын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу үйл ажиллагааныхаа тайланг гаргах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС-д нийцсэн бодлогын баримт бичгийг батлуулж мөрдөж ажиллах;
- Олимпийн бэлэг тэмдгийг хамгаалах тухай Найробын гэрээний дагуу Оюуны өмчийн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргүүлэн харти болон дүрэмд заасны дагуу хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийг байгуулж, олимпийн эд хөрөнгө, өмчийг хамгаалах үүргээ хэрэгжүүлэн хяналтыг сайжруулж ажиллах;
- Хянан шалгах зөвлөлийн бүрэлдэхүүнд дүрэмдээ заасан шалгуурыг хангасан гишүүнийг дэвшүүлж, дүрмийн биелэлт, удирдлагын шийдвэрүүд, санхүүгийн болон спорт холбоодын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах;
- Гишүүн холбоодын үйл ажиллагааг үнэлэх, нэгдсэн бодлогоор хангах, жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцүүлж хэвших, гишүүд, хандивлагч, олон нийтийг ил тод, нээлттэй мэдээ мэдээллээр хангах боломжийг бүрдүүлэх;
- ОУЭСН, АОХ-оос хэрэгжүүлж буй тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахад байгуулж буй дөрвөлсөн гэрээ, хэлцлийг тамирчин, дасгалжуулагч хүсэл зорилгоо илэрхийлэх нөхцөл боломжоор хангах, хөтөлбөрт хамрагдах спортын төрлийг нэмэгдүүлэх, спортын салбарын бүлэг давхаргын эрх ашгийг хамгаалах, дүрмийн хүрээнд Төрийн болон бусад байгууллагатай хамтын ажиллагааг сайжруулах;
- Аудитын тайлангийн 2.15, 2.20-2.25 дахь хэсэгт дурдсан Төрийн бус байгууллагын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндсөн байж болзошгүй гэм буруугийн үйлдлийг бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн хууль хяналтын байгууллагад шалгуулж шийдвэрлүүлэх;

Шалгагдагч байгууллагын ирүүлсэн санал:



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛИМПИЙН ХОРОО

14210 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө, Утас: 34-52-85, 34-52-91,
Факс: 34-35-41, E-mail: noc@olympic.mn

Асат. 01.22 № 1/06
танай -ны № -т

☐ Дүгнэлтэд хариу тайлбар хүргүүлэх
тухай

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Д. ЗАНДАНБАТ ТАНАА

МҮОХ-ны үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитын төслийг хүлээн авч танилцлаа.

Төрийн аудитын стандарт, гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан шалгах, дүн шинжилгээ хийх явцад **МҮОХ нь Төрийн бус байгууллага** тул төрийн стандартад нийцэхгүй, өөрийн гэсэн онцлогийг байгууллагын дүрэм, журмаар зохицуулах асуудлыг Гишүүдийн хурлаар хэлэлцэж, дүрмээр баталгаажуулсан бөгөөд ОУОХ-ны Харти, МҮОХ-ны дүрмээс гадуур ямарваа үйл ажиллагаа явуулаагүй гэж үзэж байна.

Төрийн аудитын үндсэн зорилт нь *“Төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг хууль ёсны дагуу арвиран хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр төлөвлөх, хуваарлах, ашиглах, зарцуулахад хяналт тавих, түүнчлэн төрийн санхүүгүйн удирдлагыг сайжруулж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ”* гэж заасан байна.

Үндэсний аудитын газрын төлөвлөгөөнд үндэслэл болгосон Төрийн Аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дугаар заалтууд нь Төрийн бус байгууллага болох МҮОХ-нд үл нийцэж байсан билээ. Гэвч бид **Төрийн аудитийн тухай хууль** болон төрийн байгууллагын үзэл баримтлал, үйл ажиллагааг хүндэтгэж, төлөвлөгөөний дагуу шаардлагатай баримт бичиг, материалаар хангаж ажилласан бөгөөд дүгнэлттэй танилцаад дараах хариуг хүргүүлж байна.

НЭГ. Аудитын тайлангийн 2.15-д Засгийн газрын 2012 оны 128 дугаар тогтоолын дагуу тамирчдын хүч чадлыг нэмэгдүүлэх үйлчилгээтэй нэмэлт бүтээгдэхүүн авахад зориулж ССАЖЯ-наас 200.0сая төгрөг олгосон бөгөөд бүтээгдэхүүнийг орлого авч, зарцуулсныг нотлох баримтгүй тул хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шийдвэрлэсэн гэжээ.

Уламжлалт анагаах ухаан, оюун санааны хөгжил сан нь 2008 онд Монгол улсад Олимпийн анхны аваргуудыг төрүүлэх үйл хэрэгт өөрийн хувь нэмрийг оруулсан нь төр засгаас үнэлэгдэн 2012 оны Лондонгийн олимпийн наадамд оролцох тамирчдыг мөн дэмжихэд хамтран ажиллахаар шийдвэрлэж, санхүүжүүлсэн байна. Тус сангийн эрдэмтэн судлаачдын гаргасан нэмэлт бүтээгдэхүүн нь зөвхөн Монгол тамирчдын онцлогийг

харгалзан, тамирчин тус бүрийн бие бялдарт зориулсан тусгай жороор бүтээгдсэн шинэ бүтээл юм.

Мөн Тамирчин нөхөн сэргээх сувилал ХХК нь тамирчдыг тав тухтай орчинд байрлуулах, байнгын эмчийн үзлэг хяналтан дор шим тэжээлтэй хоол хүнсээр хангах чиглэлээр хамтран ажиллаж ирсэн бөгөөд тамирчдыг байрлах хугацаанд нэмэлт бүтээгдэхүүнээр хангаж иржээ. Засгийн газрын санхүүжилтийг эдгээр үйл ажиллагаанд зарцуулсан болох нь анхан шатны баримтуудаар нотлогдож байх тул хууль хяналтын байгууллагад шалгуулах тухай асуудлыг аудитын тайлангаас хасч өгөхийг хүсч байна. Лондон 2012 Олимпийн наадмаас Монгол улс түүхэндээ анх удаа хамгийн олон буюу 5 тамирчин олимпийн медаль хүртсэн бахдам амжилтыг үзүүлсэн нь бидний хамтын ажиллагааны үр дүн харагдаж байна.

ХОЁР. Мөн тайлангийн 2.22, 2.25, 2.26-д МҮОХ-ны газрыг спорт холбоодод албан тушаалаа ашиглан дур мэдэн шилжүүлсэн, ТНСС-г барихад банкнаас зээл авахад баталгаа гаргаж өгөх, ТНСС-ын барилгыг шилжүүлэхийг зөвшөөрсөн тухай шийдвэр нь албан тушаалын байдлаа ашиглан хөрөнгө завшсан байж болзошгүй нөхцөл байдал, МҮОХ-ны эзэмшил газраас бусдад шилжүүлэхдээ эрх мэдлээ хэтрүүлсэн нөхцөл байдал үүссэн байж болзошгүй тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар шийдвэрлэв гэжээ.

Гэвч дээрх асуудлуудыг 2013 онд:

- Монгол улсын Авилгатай тэмцэх газар
- Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
- Сүхбаатар дүүргийн шүүх
- Нийслэлийн цагдаагийн газар
- АТГ-ын аудитын газар зэрэг байгууллагууд МҮОХ-ны 2000-2013 оны санхүү болон архивын бүх материалыг жилийн хугацаанд шалгаж Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2014 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 173 тоот тогтоолын дагуу МҮОХ-ны Ерөнхийлөгч асан Д. Загдсүрэнд доорх ялыгоноосон билээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 248 дугаар зүйлийн 248.1.1 дэх хэсэг, 283, 286, 295, 296, 297, 298, 299 дүгээр зүйлийн 299.1, 301 дүгээр зүйлийн 301.1д хэсэгт заасныг удирдлага болгон тогтоосноор: *МҮОХ Ерөнхийлөгч асан Д.Загдсүрэнг хууль тогтоомж дүрмээр олгогдсон эрх мэдлээ илтэд хэтрүүлсний улмаас ТББ-ын хууль ёсны эрх, ашиг сонирхолд онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож Эрүүгийн хуулийн тусгай ангийн 266 дугаар зүйлийн 266.2 дахь хэсэгт зааснаар түүний албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг 2 жилийн хугацаагаар хасч, 3 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгүүлсэн*” юм.

Одоогоор МҮОХ-ны Ерөнхийлөгч асан Д.Загдсүрэн нь хорт хавдрын улмаас биеийн байдал маш хүнд, байнгын эмнэлгийн хяналтад эмчилгээтэй байгаа зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзэж, нэгэнт шүүхээр шийтгэгдсэн асуудлаар дахин хууль хяналтын байгууллагаар шалгуулахшаардлагагүй гэж МҮОХ-ны зүгээс үзэж байгаа тул 2.25, 2.26 дахь дүгнэлтүүдийг аудитын дүгнэлтээс хасч өгөхийг хүсч байна.

ГУРАВ. Бид Төрийн аудитын байгууллагын дүгнэлт, зөвлөмжийн дагуу МҮОХ-ны дүрэм, зарим үйл ажиллагаанд МУ-ын холбогдох хууль дүрэм журамд нийцүүлсэн нэмэлт өөрчлөлтийг оруулах, засч сайжруулах, цаашид үйл ажиллагааны төлөвлөлтийг илүү нарийвчлалтай гаргаж, гүйцэтгэлийг дүгнэх журмыг тодорхой болгох зэрэг асуудлыг

МҮОХ-ны бүх гишүүдэд танилцуулан, МҮОХ-ны дүрмийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах болно.

Үүнд: МҮОХ нь Үндэсний аудитын газрын зөвлөмжийн дагуу :

- МҮОХ-ны үүсгэн байгуулагч, гишүүдийн асуудлыг хурлаар хэлэлцэж шинэчилсэн бүртгэлд хамруулах, гэрчилгээ авах
- МҮОХ-ний гишүүнчлэл болон ОУОХ-ны зөвлөмжийг Гишүүдийн хуралд дахин танилцуулж, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх асуудлыг дахин хэлэлцэх
- Гишүүн холбоодын сонгуульт албан тушаал эрхэлж буй этгээд нь шийдвэр гаргахад сонирхлын зөрчилтэй байвал санал хураалтад оролцуулахгүй байх нэмэлт өөрчлөлтийг дүрмэнд оруулах эсэхийг гишүүдээр хэлэлцүүлэх
- Олимпийн бэлэг тэмдгийг хамгаалах Найробын гэрээний дагуу Олимпийн эд хөрөнгө, өмчийг хамгаалах талаар Оюуны өмчийн газарт бүртгүүлсэн байгаа бөгөөд хамтын ажиллагааны гэрээний дагуу холбогдох газруудад хамтарсан шалгалт хийж, шаардлага тавин, хэмжээ авч ажиллаж байсан. Энэхүү үйл ажиллагааг эрчимжүүлж, аудитад дурьдагдсан Токио олимп сан болон бусад зөвшөөрөлгүй газруудад арга хэмжээ авч ажиллах
- Хянан шалгах зөвлөлийн үйл ажиллагааны хамрах хүрээг нэмэгдүүлэх, хяналтыг сайжруулах талаар арга хэмжээ авах
- Гишүүн холбоодод аудитын дүнг танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллах

зэрэг үйл ажиллагааг МҮОХ-ны Гишүүдийн хуралд танилцуулж, арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

1956 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирсэн 60 гаруй жилийн түүхтэй байгууллагын үйл ажиллагааг 2012 оноос хойшхи хэдхэн баримт материал, гүйцэтгэсэн ажлын тайланд дүгнэлт хийснээр бүрэн тодорхойлж, өрөөсгөл дүгнэх боломжгүй бөгөөд ямар аргачлал, хууль эрх зүйн үндэслэл, дүрэм журмыг үндэслэн ямар байгууллага, яаж шалгаснаас шалтгаалан үр дүн харилцан адилгүй гарах бөгөөд бид энэ асуудлаар холбогдох байгууллага, Олон улсын арбитрын шүүх, Олон улсын олимпийн хороонд хандаж зөвлөгөө авах болно.

Үндэсний аудитын газрын аудитуудад мэргэжлийн өндөр түвшинд Ковид19 цар тахлын үед ч тасралтгүй ажиллаж, МҮОХ-ны үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр зөвлөмж зөвлөгөө өгч ажилласанд талархал илэрхийлэхийн ялдамд Та бүхний үйл хэрэгт амжилт хүсч, цаашид хамтран ажиллахад бэлэн байгаагаа үүгээр илэрхийлье.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н. ТҮВШИНБАЯР

Хавсралтууд

Хүснэгт 1. МҮОХ-ны 2012-2019 оны үйл ажиллагааны төсөв, гүйцэтгэлийн судалгаа

/сая төгрөг/

д/д	Он	Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл		Хэтрэлт/+, хэмнэлт -/	Тайлбар
				дүн	хувь		
1	2012	Захиргаа аж ахуй		231.8		231.8	ГЗХ-ын төсөв баталсан тогтоол нь байгаа ч төсвийн хавсралт, тоон дүнгүүд байхгүй
		Хөтөлбөр арга хэмжээ		790.2		790.2	
		Бусад*		205.7		205.7	
		Дүн	-	1,227.7		1,227.7	
2	2013	Захиргаа аж ахуй	262.7	211.7	80.6	-51	
		Хөтөлбөр арга хэмжээ	171.1	224.1	131.0	53	
		Бусад*	207.2	123.9	59.8	-83.3	
		Дүн	641.0	559.7	87.3	-81.3	
3	2014	Захиргаа аж ахуй	264.7	244.0	92.2	-20.7	
		Хөтөлбөр арга хэмжээ	694.1	1,067.5	153.8	373.4	
		Бусад*	323.4	104.5	32.3	-218.9	
		Дүн	1,282.2	1,416.0	110.4	133.8	Хэтрүүлсэн
4	2015	Захиргаа аж ахуй	282.0	363.6	128.9	81.6	
		Хөтөлбөр арга хэмжээ	451.1	656.5	145.5	205.4	
		Бусад*				0	
		Дүн	733.1	1,020.1	139.1	287.0	Хэтрүүлсэн
5	2016	Захиргаа аж ахуй	266.0	338.1	127.1	72.1	
		Хөтөлбөр арга хэмжээ	500.0	1,019.7	203.9	519.7	
		Бусад*	220.0	102.8	46.7	-117.2	
		Дүн	986.0	1,460.6	148.1	474.6	Хэтрүүлсэн
6	2017	Захиргаа аж ахуй	420.5	428.8	102.0	8.3	
		Хөтөлбөр арга хэмжээ, наадам оролцох	518.0	966.1	186.5	448.1	
		Бусад*	215.3	155.7	72.3	-59.6	
		Дүн	1,153.8	1,550.6	134.4	396.8	Хэтрүүлсэн
7	2018	Захиргаа аж ахуй	366.0	364.6	99.6	-1.4	
		Хөтөлбөр арга хэмжээ, тив бүсийн наадам оролцох	719.2	761.2	105.8	42.0	
		Бусад*	300.6	270.7	88.7	-34.0	
		Дүн	1,385.8	1,392.4	100.5	6.6	Хэтрүүлсэн
8	2019	Захиргаа аж ахуй		453.0		453.0	Төсөв батлуулаагүй.
		Хөтөлбөр арга хэмжээ, тив бүсийн наадам оролцох		594.4		594.4	
		Бусад*		120.0		120.0	
		Дүн	-	1,167.4		1,167.4	

Бусад*-Олимпийн сургалт сурталчилгаа, тэмцээн, дотоод арга хэмжээ, холбоодын бүтцийг сайжруулах, гадаад арга хэмжээ гэх мэт